МОНГОЛ УЛСЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТЕНДЭРИЙН САНХҮҮГИЙН ЧАДАВХЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫН ЭМПИРИК СУДАЛГАА

Д.Цэвэлмаа[1a]
[1] Мандах Их Сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхим, Ахлах багш
[a] tsevelmaa@mandakh.edu.mn

Өгүүлэл хүлээн авсан огноо: 20/05/2026
Өгүүлэл хэвлэсэн огноо: 01/07/2026
https://doi.org/10.67207/mrj.2026.15.09

ХУРААНГҮЙ

530 тендерийн өгөгдлийн хүснэгтийн “санхүүгийн шалгуур” хэсгийг чанарын кодчилол, тоон шинжилгээ (descriptive, Spearman, Kruskal–Wallis, ANOVA) -гаар боловсруулсан. Санхүүгийн шалгуур хэсгийг борлуулалтын орлогын шалгуур, түргэн хөрвөх хөрөнгийн шалгуур, өр зээлийн шалгуур гэсэн үндсэн 3 бүлгээр нийт 12 үзүүлэлтээр Tender.gov.mn-ээс чанарын судалгааны үзүүлэлтээр шүүж авч 6890 ширхэг мэдээллийг тоон судалгаарууулан SPSS дээр боловсруулалт хийж дүгнэлээ. Ингэхдээ 5 таамаглал дэвшүүлж 3 таамаглал батлагдлаа. Тоймлон хүргэвэл Зарласан тендэрийн төсөвт өртөг нэмэгдэх тусам шалгуур үзүүлэлтийн “Өр зээлийн шалгуур үзүүлэлт” нэмэгдэх боловч энэ нь статитикийн хувьд бага нөлөөтэй гарлаа. Харин борлуулалтын орлогын суурь хувь, түргэн хөрвөх хөрөнгийн харьцааг тодорхойлох суурь хувь хэмжээ нэмэгдэхгүй буюу хамааралгүй гарч байна.

Борлуулалтын орлогын хамрах хүрээ нь санхүүгийн шалгуурын модульд хамгийн өндөр хамааралтай хувьсагч байв. Kruskal–Wallis шинжилгээгээр SRC үзүүлэлтийн бүлгүүдийн хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илэрсэн ($p < .001$), мөн ANOVA шинжилгээгээр ч ялгаа хүчтэй ($F=19.992$, $p<.001$) гарсан нь борлуулалтын орлогын хүрээ өөрчлөгдөхөд SRC-ийн босго системтэйгээр өөрчлөгдөж буйг харуулж байна.

Судалгаанд “харилцах дансны үлдэгдэл”, “харилцагч банкнаас авч болох зээлийн дүнг тусгасан албан бичиг”, “үнэт цаас шаардах” зэрэг банкнаас гаргуулах суурь нотлох бариимтууд давтамж өндөртэй буюу зарласан тендэрийн 93–97% байгааг ажиглав. Энэ нь санхүүгийн шалгуурын модульд банкны нотолгоо де-факто стандарт болж тогтож байгааг илтгэх боловч тендер бүрд бариимтын төрөл, шаардлагын хэлбэр өөр өөр байгаа нь оролцогчдод “нэг төрлийн ажилд өөр өөр багц шаардлага” үүсгэж буйг харуулж байна. Энэхүү судалгаа нь тендэрийн санхүүгийн шалгуурын ялгаатай байдлын бүтцийг микро түвшинд өгөгдлийн хүснэгт ашиглан чанарын болон тоон судалгааны аргыг хослуулсан анхны судалгаа бөгөөд үр дүнг бодлого төлөвлөлтөнд шууд хэрэгжих боломжтой нэгдсэн шалгуурын загвар боловсруулах үндэс болно.

Түлхүүр үг: Тендэр, санхүүгийн шалгуур, стандартчилал, худалдан авах ажиллагаа

ОРШИЛ

Судалгааны үндэслэл

Монгол улсын хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан төсвийн хөрөнгөөрх бүтээн байгуулалтыг худалдан авах үйл ажиллагааны тухай хуульд зааснаар Төсвийн захирагч тендэр зарлаж бүтээн байгуулалтын шалгаруулалтын үе шатаар хийдэг. Гэсэн хэдий ч төсвийн захирагч бүрийн тендэрийн бичиг баримтын шалгуурууд харилцан адилгүй байгаа тул үүнийг судлан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шалгаж бодлого тодорхойлогч нарт судалгааны үндэслэлтэй шийдвэр гаргаж цаашдын бодлого төлөвлөлтийг сайжруулах, стандартчилах хэрэгцээ байгаа тул судалгааг хийсэн.

Судалгааны зорилго

Нэг ижил ажилд шаардагдах шалгуур үзүүлэлтийн ялгаатай байдлыг судалснаар хөрөнгө оруулалтын төсвөөс зарласан ажилд тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг ижил болгох суурь судалгааг үндэслэлтэй хийж тухайн чиглэлээр дагнан бүтээн байгуулалт хийдэг хуулийн этгээдүүдэд тэгш байдлыг хангаж өгөх.

Судалгааны зорилт

- Тендэрийн сонгон шалгууруулалт явуулахад цаашид ашиглах боломжтой
- Тодорхой чиглэлийн ажлуудыг шалгаруулалтын үзүүлэлтийн нэгдсэн сан үүсгэх суурь дата бэлтгэж гаргах
- Ялгаатай шалгуур үзүүлэлтийг зогсоох
- Шалгуур үзүүлэлтүүдийг стандартчилахад ашиглах

Судалгааны ажлын шинэлэг тал

- Бүтээн байгуулалтын тендэрт оролцогчдод шалгуур үзүүлэлтийн нэгдсэн сантай болох
- Бүтээн байгуулалтын тендэрийн одоогийн байгаа ялгаатай байдлыг харуулсан
- Дараа жилүүдэд зарлах сонгон шалгаруулалтын үзүүлэлтийг ижил болгох суурийг бэлтгэсэн
- Монгол улсад тендерийн санхүүгийн шалгуур үзүүлэлтийн ялгаатай байдлыг тусгайлан судалсан эрдэм шинжилгээний ажил бараг байдаггүй нь энэхүү судалгааны шинэлэг байдлыг тодорхой харуулж байна.

Судлагдсан байдал

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тендэрийн үйл ажиллагаатай холбоотой 3 том эрх зүйн актын хувьд санхүүгийн шалгуур үзүүлэлтийн үндэслэлийн талаар хуульчилсан байдлыг үзвэл:

“САНХҮҮГИЙН ШАЛГУУРЫН МОДУЛЬ”-ЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

№	Эрх зүйн акт / зүйл, заалт	Агуулга (санхүүгийн шалгууртай холбоотой)	Судалгаанд ашиглах утга
1	БАҮХТХ (2023) – 16 дугаар зүйл	Захиалагч оролцогчийн санхүүгийн чадавх, техникийн чадавх, туршлагын доод шаардлага тогтоож болно.	Санхүүгийн шалгуур тавих хууль эрх зүйн үндэс. Чиглэлүүдийн хооронд шалгуурын *ялгаатай* байдал үүсэх шалтгаан.
2	БАҮХТХ – Санхүүгийн нотлох баримт (16 дугаар зүйл)	Шаардах боломжтой баримтууд: банкны мэдэгдэл, санхүүгийн тайлан (3 жил), борлуулалтын орлого, аудитын дүгнэлт.	SRC, CRC, Time, Lav/Tod/Legal, bank requirements зэрэг судалгааны хувьсагчдын хууль зүйн үндэс.
3	БАҮХТХ – 11.2 дугаар зүйл	Тендерийн баримт бичигт санхүүгийн шалгуур, нотлох баримтын жагсаалт заавал тусгана.	Стандарт ТШББ-д шалгуур “заавал тусгах ёстой” → бодит ТШББ-уудын ялгааг тайлбарлахад суурь.

4	БАҮХТХ – 54.5–54.7 (цахим систем, мэдээллийн үнэн зөв)	Санхүүгийн чадавх, туршлагын мэдээллийг цахим системд байршуулж, үнэн зөвийг оролцогч хариуцна.	Судалгааны лавлагааны өгөгдөл (dataset)-ийн бодит эх үүсвэр ба үнэн зөвийг хангах зохицуулалт.
5	БАҮХТХ – 42 дугаар зүйл (Тендерийн баталгаа)	100 сая төгрөгөөс дээш өртөгтэй тендерт тендерийн баталгаа, хэмжээ нь төсөвт өртгийн 0.5%.	Санхүүгийн сахилга, эрсдэлийн шалгуурын ойлголт.
6	БАҮХТХ – 42.2 дугаар зүйл (Гүйцэтгэлийн баталгаа)	Гүйцэтгэлийн баталгаа: тухайн жилд санхүүжих дүнгийн 3%.	“Financial discipline” ба эрсдэлийн удирдлагын механизмыг тайлбарлана.
7	БАҮХТХ – 23 дугаар зүйл (80%-иас доош үнэ)	Төсөвт өртгийн 80%-иас доош үнийн санал өгсөн бол үндэслэл бүхий тайлбар заавал ирүүлнэ.	“Abnormally low bid” үзэгдлийн Монгол дахь хууль зүйн үндэс.
8	БАҮХТХ – 51.4, 50.2 (үнэлгээний хороо баримт шаардах эрх)	Үнэлгээний хороо нотлох баримт шаардах, тодруулга авах бүрэн эрхтэй.	Санхүүгийн мэдээллийн баталгаажуулалтын механизмыг тайлбарлах боломж.
9	Төсвийн тухай – 5 дугаар зүйл (Төсвийн зарчим)	Төсөв нь ил тод, үр ашигтай, хэмнэлттэй зарчмыг баримтална.	Санхүүгийн шалгуурын учир шалтгааны суурь (зардал, эрсдэл, хариуцлага).
10	Төсвийн тухай – 4.1.5–4.1.7 (Төсөвт өртөг)	Төсөв нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, төрийн шийдвэрээр баталгаажна.	Судалгааны “батлагдсан төсөвт өртөг (Budget_k)” хувьсагчийн хууль зүйн үндэс.
11	Хөрөнгө оруулалтын тухай – 7.2.1–7.2.4 (Санхүүгийн мэдээлэл, аудит)	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч нь санхүүгийн мэдээллийг үнэн зөв тайлагнах, аудит хийлгэх үүрэгтэй.	Санхүүгийн тайлан + аудитын шаардлагын хууль эрх зүйн үндэслэл.

(Хөрөнгө Оруулалтын Тухай Хууль, 2013)
(Төсвийн Тухай Хууль, 2011)
(Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хууль, 2023)

Сүүлийн үеийн судалгаануудад тендерийн үнэлгээний шалгуур нь зөвхөн техникийн болон санхүүгийн үзүүлэлт төдийгүй институцийн орчин, засаглалын чанараас ихээхэн хамаардаг болохыг онцолж байна. Жишээлбэл, PBEC (performance-based evaluation criteria)-д төвлөрсөн судалгаагаар үнэлгээний шалгуурын тодорхойлолт нь захиалагчийн шийдвэр гаргах эрх мэдэлд тулгуурладаг бөгөөд энэ нь авлига, хариуцлага зэрэг институцийн хүчин зүйлсийн нөлөөнд автдаг болохыг харуулжээ. (Cao & Wang, 2023)

Төр-хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийн амжилт нь голлон тендерийн үйл явцын гүйцэтгэлээс хамаардаг. Судалгаагаар Төр-хувийн хэвшлийн түншлэлийн (Public–Private Partnerships - PPPs) тендерийн хэрэгжилтэд нөлөөлөх 14 чухал хүчин зүйлийг тодорхойлж, тэдгээрийг 7 хэмжээсэд ангилсан байна. (Liu et al., 2016)

Хөрөнгө оруулалтын тендерийн үнэлгээний шалгуурын чиглэлээр олон улсад өргөн хэрээнд судалгаа хийгдсэн байдаг. (Zedan Hatush, 1998) нь гүйцэтгэгч сонгох нэгдсэн шалгуурын загварыг боловсруулж, санхүүгийн тогтвортой байдал, техникийн чадавх, өмнөх туршлага зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэсэн байдаг. Тендерийн үнэлгээний шалгуур нь худалдан авах ажиллагааны үр ашгийг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг болохыг олон улсын судалгаанууд онцолж байна. (Gálvez-Rodríguez et al., 2024) нарын судалгаанд төрийн худалдан авах ажиллагааны үр ашгийн талаарх судалгааны дэлхийн чиг хандлагыг шинжилж, тендерийн үнэлгээний шалгуурын олон улсын bibliometric судалгаандаа хамгийн бага үнийн шалгуур (Lowest Price) болон олон шалгуурт (Multi-criteria assessment) хандлагын ялгааг дүгнэж, стандартчиллын хэрэгцээг онцолсон байна.

Cao & Wang (2023) нар төр болон хувийн хэвшлийн түншлэл тендэрийн (Public–Private Partnerships - PPPs) үнэлгээний шалгуурын ялгаатай байдал нь захиалагчийн үзэмжээс хэт хамааралтай байдгийг нотолж, тодорхой хэм хэмжээ тогтоох шаардлагыг дэвшүүлсэн. Олон улсын практикт санхүүгийн чадамжийн үнэлгээ нь нийлүүлэгч тухайн гэрээг санхүүгийн хувьд тогтвортой, тасралтгүй гүйцэтгэх чадвартай эсэхийг баталгаажуулах гол хэрэгсэл гэж үздэг. Европын холбоо санхүүгийн чадамжийн үнэлгээний аргачлалд “санхүүгийн шалгуур нь сонгон шалгаруулалтын шалгуур бөгөөд гэрээний хэрэгжилтийн эрсдэлийг бууруулах зорилготой” гэж тодорхойлсон байдаг. (European commisson, 2018) Гэрээний хэмжээ болон нийлүүлэгчийн санхүүгийн багтаамжийн уялдаа
UK-ийн орон нутгийн худалдан авалтын туршлагад “contract limit test” буюу гэрээний жилийн өртгийг компанийн жилийн борлуулалттай харьцуулж “гэрээ нь тухайн компанийн санхүүгийн багтаамжид тохирох эсэх”-ийг шалгадаг. Жишээ нь гэрээний үнэ компаниудын жилийн орлогын 10%-иас их байх нь санхүүгийн эрсдлийг нэмэгдүүлдэг гэж үздэг. (Criteria used for financial evaluation of candidates in the procurement process)
CIPS (Chartered Institute of Procurement & Supply, н.д.)-ын практик удирдамжид тендер бүрийг нэг ижил аргаар үнэлэх нь шударга өрсөлдөөнийг хангах үндсэн зарчим болохыг тусгасан байна. Тендерийн үнэлгээний шалгуур, түүний хэрэгжилт нь зөвхөн шалгуурын бүтэц төдийгүй үнэлгээний үйл явцын ил тод байдал, шударга байдалтай шууд холбоотой байдаг. Гэсэн хэдий ч бодит практикт, ялангуяа хөгжиж буй эдийн засагтай орнуудад эдгээр зарчмууд бүрэн хэрэгжихгүй байх тохиолдол элбэг бөгөөд энэ нь тендерийн шалгуур үзүүлэлтүүд, тэр дундаа санхүүгийн шалгуурын ялгаатай байдлыг улам нэмэгдүүлж болзошгүй юм.(Chartered Institute of Procurement and Supply, n.d.) Иймд тендерийн үнэлгээний үйл явцыг стандартчлах, шалгуурын хэрэгжилтийг ил тод болгох нь санхүүгийн шалгуур үзүүлэлтийн нэгдмэл, шударга тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Судалгааны таамаглал

H1 Нэг ижил ажилд сонгон шалгаруулалтын үзүүлэлтүүд ялгаатай байгаа

H2 Батлагдсан төсвийн дүн сонгон шалгаруулалтын үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг

H3 Батлагдсан төсөвт өртөг өндөр тендэр санхүүгийн шалгуур үзүүлэлтийн босгын хувь өндөр байдаг

H4 Батлагдсан төсөвт өртөг бага байх тусам санхүүгийн шалгуур үзүүлэлтийн тоо буурдаг

H5 Санхүүгийн шалгуур үзүүлэлтийн тоо батлагдсан төсөвт өртөгтэй хамааралгүй

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хөрөнгө оруулалтын төсвийн зарцуулалтыг хийх сонгон шалгаруулалтын нэгдсэн зарлал Монгол улсад tender.gov.mn хаягт улсын хэмжээнд зарлагддаг. 2024 онд Хөрөнгө оруулалтын төсөвт суусан төслүүдтэй холбоотой 577 тендер зарлагдсанаас нээлттэй ашиглах боломжтой датаны шалгуур хангасан 530 тендэрийн өгөгдлийн хүснэгтийн мэдээллийн “Санхүүгийн шалгуур” хэсэгт анализ хийсэн. Судалгааны хувьсагчид нь Борлуулалтын орлого, Батлагдсан төсөвт өртөг, Түргэн хөрвөх хөрөнгө, Санхүүгийн босгын хувь, Түргэн хөрвөх хөрөнгийн босгын хувиуд, бусад үзүүлэлт байна. Тус үзүүлэлтүүдийг Үндсэн 3 бүлгээр нийт 12 үзүүлэлтийг чанарын судалгаа хийж түлхүүр үгүүдээр шүүж авч 6890 ширхэг мэдээллийг тоон судалгааруу хөрвүүлэн SPSS дээр

боловсруулалт хийж дүгнэлээ. Spearman-ны корреляцийг тархалт нь хэвийн биш тул Pearson-ыг оронд нь ашиглав. Төсөвт өртгийн тархалт Kolmogorov-Smirnov шинжилгээгээр хэвийн бус ($p<.001$) гарсан. Kruskal-Wallis шинжилгээ нь параметр бус бөгөөд бүлэг хоорондын тархалтын ялгааг шалгахад хэрэглэгдэв. One-way ANOVA-г SRC ангиллуудаар Min criteria (SRC)-ийн ялгааг тодорхойлоход хэрэглэв. ANOVA хийхийн өмнө Levene-ийн тестээр бүлгүүдийн дисперс тэнцүү эсэхийг шалгасан бөгөөд дисперсийн тэгш байдлын нөхцөл хангагдсан ($p>.05$) тул ANOVA хэрэглэх арга зүйн үндэслэл бүрдсэн.

Судалгааны хувьсагчид

№	Хувьсагчийн нэр	Хувьсагчийн нэр	Судалгааны үүрэг	Тодорхойлолт
1	Ерөнхий төсвийн захирагч	General budget administrator (general_budget_admin)	Бүлэглэх хувьсагч	Тендэр зарласан яам/байгууллагын код (1-20)
2	Батлагдсан төсөвт өртөг	tosovt ortog / Budget_k (tosovt_ortog)	Үл хамааран хувьсагч	Тендэрийн батлагдсан төсөвт өртөг (сая төгрөг)
3	Борлуулалтын орлогын хамрах хүрээ	Sales Revenue Coverage (SRC) (sales_rev_coverage)	Хамааран хувьсагч	Борлуулалтын орлогын шалгуурын хамрах хугацаа (1=1 жил, 2=2 жил, 3=3 жил)
4	Борлуулалтын орлогын шалгуурын төрөл	Sales Revenue Criteria (sales_rev_criteria)	Хамааран хувьсагч	Борлуулалтын орлогын шалгуурыг тодорхойлох арга (6 төрөл)
5	Борлуулалтын орлогын босгын хамгийн бага хувь	Min criteria (SRC) (min_src)	Хамааран хувьсагч	Борлуулалтын орлого нь батлагдсан төсөвт өртгийн хэдэн хувь байхыг заасан доод босго
6	Түргэн хөрвөх хөрөнгийн шалгуурын төрөл	Current Ratio Criteria (CRC) (curr_ratio_criteria)	Хамааран хувьсагч	Түргэн хөрвөх хөрөнгийн шалгуурыг тодорхойлох арга (0=шаардаагүй, 1=төсөвт өртгөөр, 2=дансны үлдэгдэл, 3=бусад)
7	Түргэн хөрвөх хөрөнгийн босгын хамгийн бага хувь	Min criteria (CRC) (min_crc)	Хамааран хувьсагч	Түргэн хөрвөх хөрөнгө нь батлагдсан төсөвт өртгийн хэдэн хувь байхыг заасан доод босго
8	Харилцах дансны үлдэгдэл шаардсан эсэх	Lav (Bank account balance) (Lav)	Хамааран хувьсагч	Харилцах дансны үлдэгдлийн тодорхойлолт шаардсан эсэх (0=үгүй, 1=тийм)
9	Зээлийн мэдэгдэл шаардсан эсэх	Tod (Bank loan letter) (Tod)	Хамааран хувьсагч	Харилцагч банкнаас авч болох зээлийн дүнгийн тодорхойлолт шаардсан эсэх (0=үгүй, 1=тийм)
10	Үнэт цаас шаардсан эсэх	Legal (Securities) (Legal)	Хамааран хувьсагч	Засгийн газрын бонд болон үнэт цаас шаардсан эсэх (0=үгүй, 1=тийм)
11	Өр зээлийн шалгуурын төрөл	Loan criteria (loan_criteria)	Хамааран хувьсагч	Өр зээлийн шалгуурын тодорхойлолтын төрөл (0-4)
12	Өр зээлийн босгын хамгийн бага хугацаа	Min criteria (Time) (min_time)	Хамааран хувьсагч	Зээлгүй байх доод шаардлагын хугацаа (жилээр, 0-6)

Судалгааны үр дүн

2024 онд Хөрөнгө оруулалтын төсөвт суусан төслүүдтэй холбоотой 577 тендер зарлагдсанаас нээлттэй ашиглах боломжтой датаны шалгуур хангасан 530 тендэрийн өгөгдлийн хүснэгтийн мэдээллийн “Санхүүгийн шалгуур” хэсэгт анализ хийж үзэхэд дараах зүйлсүүд гарч байна. *Жич:* судалгаанд ороогүй 47 тендэрийн хувьд төрийн нууцтай худалдан авалтын тендэр болон тендэр өөрөө цуцлагдсан тендэрүүд байсан болно.

ХҮСНЭГТ 1 ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН НЭГТГЭЛ

Descriptive Statistics						
	N	Minimum	Maximum	Sum	Mean	Std. Deviation
general budget administrator	530	1	20	6594	12.44	6.027
tosovt ortog	530	42.0	676272.0	3173444.2	5987.631	30509.3944
sales revenue coverage	530	1	3	1469	2.77	.425
sales revenue criteria	530	1	9	1324	2.50	1.621
Min criteria (SRC)	524	.10	1.00	214.30	.4090	.17147
current ratio criteria	516	0	3	542	1.05	.338
Min criteria (CRC)	526	.00	1.00	163.20	.3103	.10428
current ratio criteria uzuulelt	529	0	3	1268	2.40	.623
hariltsah C2	525	0	1	509	.97	.172
hariltsagch banknaas avch boloh zeeliin dun shaardsan eseh	525	0	1	514	.98	.143
Unet tsaas shaardsan eseh	522	0	1	494	.95	.226
loan criteria	528	0	4	567	1.07	.527
Min criteria (Time)	520	0	6	683	1.31	1.145

- Нийт 530 тендэрийн 135 буюу 25.5% нь Боловсролын сайд, 86 буюу 16.2% Зам тээврийн сайд, 61 буюу 11.5% ХББОСС болон Эрчим хүчний сайд тус тус, 54 буюу 10.2% ССАЖЗСайдын тендэрүүд эзлэж байна.

ХҮСНЭГТ 2 ЗАРЛАСАН ТЕНДЭРҮҮД ЯАМ САЙДУУДААР

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Зам тээврийн сайд	86	16.2	16.2	20.6
	ССАЖЗС	54	10.2	10.2	34.0
	ХББОСС	61	11.5	11.5	45.8
	ХХАА, хөнгөн үйлдвэрийн сайд	28	5.3	5.3	52.8
	ЭМС	31	5.8	5.8	62.8
	Эрчим хүчний сайд	61	11.5	11.5	74.3
	Боловсролын сайд	135	25.5	25.5	99.8

- Төсөвт өртгийн хувьд тендэрийн баримт бичгийн шалгуурт хамгийн өндөр дүнтэй тендэр 46.9 тэрбум төгрөг Зам тээврийн сайдын Хатуу хүчилттай авто зам, гүүрт зарласан тендэр байсан бол хамгийн бага дүнтэй тендэр 96.5 сая төгрөгийн ССАЖЗСайдын Соёл, урлагийн цогцолборын барилгын нэмэлт санхүүжилтийн тендэр байсан байна.

ХҮСНЭГТ 3 ЗАРЛАСАН ТЕНДЭРҮҮДИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ

Тэрбум төгрөг		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	96.5	91	17.2	17.2	17.4
	1644.5	31	5.8	5.8	34.3
	2200.0	22	4.2	4.2	38.9
	2325.0	54	10.2	10.2	49.4
	2916.4	40	7.5	7.5	60.4
	3000.0	25	4.7	4.7	65.1
	3469.6	42	7.9	7.9	77.0
	4569.5	26	4.9	4.9	84.5
	10006.8	41	7.7	7.7	94.9
	46888.9	20	3.8	3.8	99.8

- Санхүүгийн чадавхын *шалгуур үзүүлэлт №1* Борлуулалтын орлогын шалгуур үзүүлэлт 3 үндсэн хэсэгтэй боловч хоорондоо харилцан адилгүй тавигдсан байна. Үүнд:
    1. Борлуулалтын орлогын хамрах хугацаа 1-3 жилийн ялгаатай хугацаагаар 410 буюу 77.4% нь 3 жилийн борлуулалтын орлогын үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт болгож байна.
    2. Шалгуур үзүүлэлтийн ялгаатай 6 төрлийн үзүүлэлт 257 буюу 48.5% нь 3 жилийн борлуулалтын орлогыг шаардаж байгаа ч Аль 1 жилийн борлуулалтын орлого нь “Батлагдсан төсөвт өртөг”суурь хувийг хангаж байхаар шалгууртаа ашиглаж байна.
    3. Тухайн шалгуур үзүүлэлтээс доошгүй байх хувь гэсэн үзүүлэлт 278 буюу 52.5% нь тухайн шалгуур үзүүлэлтийн 30% гэсэн үзүүлэлтийг, 139 буюу 26.2% нь 50% гэсэн шалгуур ашиглаж байна.

ХҮСНЭГТ 4 БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ХАМРАХ ХУГАЦААНЫ ЯЛГААТАЙ ШАЛГУУР

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	1 жил	1	.2	.2	.2
	2 жил	119	22.5	22.5	22.6
	3 жил	410	77.4	77.4	100.0
	Total	530	100.0	100.0	

ХҮСНЭГТ 5 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ЯЛГААТАЙ 6 ТӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуурууд		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	Аль 1 жилийн борлуулалтын орлогын батлагдсан төсөвт өртгийн	257	48.5	48.5	48.5
	Нийгмийн даатгал, татварын өргүй тодорхойлолт	1	.2	.2	48.7
	Борлуулалтын орлогын дундаж хэмжээ	100	18.9	18.9	67.5
	Батлагдсан төсөвт өртгийн	135	25.5	25.5	93.0
	Нийлбэр борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн	36	6.8	6.8	99.8
	Шаардаагүй	1	.2	.2	100.0
	Total	530	100.0	100.0	

ХҮСНЭГТ 6 ТУХАЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭС ДООШГҮЙ БАЙХ СУУРЬ ХУВЬ

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	.10	2	.4	.4	.4
	.20	18	3.4	3.4	3.8
	.25	2	.4	.4	4.2
	.30	278	52.5	53.1	57.3
	.40	24	4.5	4.6	61.8
	.45	2	.4	.4	62.2
	.50	139	26.2	26.5	88.7
	.60	10	1.9	1.9	90.6
	.70	22	4.2	4.2	94.8
	.80	9	1.7	1.7	96.6
	1.00	18	3.4	3.4	100.0
	Total	524	98.9	100.0	
Missing	System	6	1.1		
Total		530	100.0		

- Санхүүгийн чадавхын *шалгуур үзүүлэлт №2* Түргэн хөрвөх хөрөнгийн шалгуур үзүүлэлт шаардахгүй тендэрүүд, батлагдсан төсөвт өртгөөс суурь хувиар тооцох шалгуур, дансны үлдэгдэл харах гэсэн үзүүлэлтүүдэд хуваагдсан байна. 495 буюу 93.4% нь батлагдсан төсөвт өртөгт үндэслэн Түргэн хөрвөх хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг тооцохдоо дараах байдлаар ашиглахаар тусгажээ. Суурь хувь нь 385 буюу 72.6% нь батлагдсан төсөвт өртгөөс 30%, 61 буюу 11.5% нь батлагдсан төсөвт өртгөөс 50% ашиглаж Түргэн хөрвөх хөрөнгийн шалгуурт ашиглаж байна.

ХҮСНЭГТ 7 ТҮРГЭН ХӨРВӨХ ХӨРӨНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АШИГЛАСАН ХУВЬ

хувь		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
	.00	17	3.2	3.2	3.2
	.10	7	1.3	1.3	4.6
	.15	1	.2	.2	4.8
	.20	35	6.6	6.7	11.4
	.25	1	.2	.2	11.6
	.30	385	72.6	73.2	84.8
	.40	15	2.8	2.9	87.6
	.50	61	11.5	11.6	99.2
	.60	1	.2	.2	99.4
	.70	1	.2	.2	99.6
	.80	1	.2	.2	99.8
	1.00	1	.2	.2	100.0
	Total	526	99.2	100.0	

Мөн тендэрийн баримт бичигт шаардагдсан Түргэн хөрвөх хөрөнгийн шалгуур үзүүлэлтэд нийтлэгээр ажиглагдаж байгаа зүйл нь 2024 онд зарлагдсан нийт тендэрээс 494-514 удаа давтагдсан байна.

1. Харилцах дансны үлдэгдэл 96%
2. Харилцагч банкнаас авч болох зээлийн дүнг тусгасан албан бичиг 97%
3. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд шаардсан 93.2% байна.

- Санхүүгийн чадавхын *шалгуур үзүүлэлт №3* Өр зээлийн шалгуур үзүүлэлт хэсэг 4 төрлийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлт, дотроо 6 төрлийн шалгуур үзүүлэлтэнд ашигласан байна. Үүнд:

1. Тодорхойлолтын хувьд 489 буюу 92.6% нь Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолтыг шаардсан, ямар 1 төрлийн тодорхойлолт шаардаагүй 13 буюу 2.5% байсан байна.
2. Тодорхойлолт доторх үзүүлэлтээс 451 буюу 85.1% нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх шалгуур, 37 буюу 7% нь зээлийн ангилал хэвийн байх шалгуур, 8 буюу 1.5% нь дуусаагүй зээлийн хэмжээ гэснийг шалгуур болгон тендэр зарласан байна.

А. Spearman' корреляцийн шинжилгээний үр дүн

Correlations						
			tosovt ortog	Min criteria (SRC)	Min criteria (CRC)	Min criteria (Time)
Spearman's rho	tosovt ortog	Correlation Coefficient	1.000	-.044	-.077	.190***
		Sig. (2-tailed)	.	.318	.078	<.001
		N	530	524	526	520
	Min criteria (SRC)	Correlation Coefficient	-.044	1.000	.315***	-.001
		Sig. (2-tailed)	.318	.	<.001	.974
		N	524	524	521	514
	Min criteria (CRC)	Correlation Coefficient	-.077	.315***	1.000	-.049
		Sig. (2-tailed)	.078	<.001	.	.270
		N	526	521	526	517
	Min criteria (Time)	Correlation Coefficient	.190***	-.001	-.049	1.000
		Sig. (2-tailed)	<.001	.974	.270	.
		N	520	514	517	520
***. Correlation is significant at the 0.001 level (2-tailed).						

Зарласан тендэрийн төсөвт өртөг нэмэгдэх тусам шалгуур үзүүлэлтийн “Өр зээлийн шалгуур үзүүлэлт” нэмэгдэх боловч энэ нь статитикийн хувьд бага нөлөөтэй гарлаа. Харин борлуулалтын орлогын суурь хувь, түргэн хөрвөх хөрөнгийн харьцааг тодорхйолох суурь хувь хэмжээ нэмэгдэхгүй буюу хамааралгүй гарч байна.

Б. Kruskal-Wallis шинжилгээний үр дүн

Independent-Samples Kruskal-Wallis Test Summary	
Total N	529
Test Statistic	6.017[a]
Degree Of Freedom	3
Asymptotic Sig.(2-sided test)	.111

Зарласан тендэрийн төсөв өсөх тусам босго чангардаг эсэхийг Батлагдсан төсөвт өртөг нь “Хөрвөх хөрөнгийн харьцаа”-ны үзүүлэлтийн ангиллуудын дагуу ялгаатай эсэхийг параметр бус Kruskal–Wallis шинжилгээгээр үнэлэв. Үр дүнд бүлгүүдийн хооронд төсөвт өртгийн тархалтын статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй H(3)=6.017, p=.111

Өөрөөр хэлбэл: Төсвийн хэмжээнээс хамаарч тавьж буй шаардлага өөр өөр байдаг уу гэдгийг “current ratio criteria” үзэхэд ялгаа байдаггүй гэдэг нь нотлогдож байна.

В. ANOVA шинжилгээний үр дүн

Борлуулалтын орлогын хамрах хүрээ (sales revenue coverage) нь санхүүгийн шалгуурын модульд хамгийн өндөр хамааралтай хувьсагч байв. Kruskal–Wallis шинжилгээгээр SRC үзүүлэлтийн бүлгүүдийн хооронд статистикийн ач холбогдолтой ялгаа илэрсэн ($p < .001$),

мөн ANOVA шинжилгээгээр ч ялгаа хүчтэй (F=19.992, p<.001) гарсан нь борлуулалтын орлогын хүрээ өөрчлөгдөхөд SRC-ийн босго системтэйгээр өөрчлөгдөж буйг харуулж байна.

Харин CRC үзүүлэлтийн хувьд ANOVA шинжилгээнд ач холбогдолтой ялгаа илэрсэн (p<.001) боловч тархалтын ялгааг шалгасан Kruskal–Wallis тестэд ач холбогдолгүй (p=.074) гарсан тул CRC-ийн бүлэг хоорондын ялгаа статистикийн хувьд хангалттай баталгаатай бус гэж үзэв.

Батлагдсан төсөвт өртөг (tosovt ortog) нь sales revenue coverage болон current ratio criteria–ийн аль ч ангиллын хувьд статистикийн ач холбогдолтой ялгаа үзүүлээгүй (Kruskal–Wallis p=.888; ANOVA p=.887). Энэ нь төсөвт өртөг шалгуурын хэлбэр өөрчлөгдөхөд мэдэгдэхүйц системтэй хамааралгүй болохыг илтгэнэ.

Корреляцийн шинжилгээгээр төсөвт өртөг нь SRC (ρ=-.044, p=.318) болон CRC (ρ=-.077, p=.078) үзүүлэлттэй ач холбогдолтой хамааралгүй, харин Time шалгууртай сул боловч статистикийн ач холбогдолтой (ρ=.190, p<.001) хамааралтай байв.

Иймд судалгаанаас харахад **санхүүгийн шалгуурын ялгаа нь төсөвт өртөгтэй бус**, харин **борлуулалтын орлогын хамрах хүрээтэй** илүү өндөр уялдаатай байна.

Г. Chi-Square шинжилгээний үр дүн

ХҮСНЭГТ 8 CHOICE БА САНХҮҮГИЙН НОТЛОХ БАРИМТ/ӨР-ЗЭЭЛИЙН ШАЛГУУРЫН ХАМААРЛЫН НЭГТГЭЛ

		Cramer's V	χ^2 (Pearson)	Df	P-Value	Valid N
choice * *Lav*		.273	39.01	3	< .001	524
choice * *Tod*		.448	104.94	3	< .001	524
choice * *Legal*		.345	61.85	3	< .001	521
choice * *loan criteria*		.312	153.92	12	< .001	528
choice * Min criteria (Time)		.351	192.07	18	< .001	520

Энэ үр дүн нь батлагдсан төсөвт өртөг нь current ratio-ийн шалгуурыг ямар хэлбэрээр шаардсан эсэхээс (батлагдсан төсөвт өртөг / дансны үлдэгдэл / шаардахгүй) үл хамааран тогтвортой ялгаатай болох хандлага статистикийн түвшинд батлагдаагүйг харуулж байна.

ДҮГНЭЛТ

1. Санхүүгийн шалгуур 1 ижил ажлуудад ялгаатай тогтоогдож байгааг нотоллоо. Тухайлбал, борлуулалтын орлогын хамрах хугацаа 1–3 жилээр, мөн шалгуурын төрөл 6 өөр хэлбэрээр, суурь хувь 10-100%-ийн хүрээнд ялгаатай тавигдсан. Энэ нь таамаглал 1-ийг баталж байна.
2. Борлуулалтын орлогын хамрах хүрээ нь SRC босготой статистикийн хувьд тогтвортой холбоотой (p < .001) бөгөөд SRC ба CRC хооронд дунд зэргийн эерэг хамаарал (ρ=.315, p<.001) илэрсэн нь санхүүгийн босгуудыг “зэрэгцүүлэн” тогтоох хандлага байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, захиалагч нар борлуулалтын орлого болон түргэн хөрвөх хөрөнгийн босгыг хамтад нь өндөр эсвэл хамтад нь бага тавих

хандлагатай байгаа нь шалгуур үзүүлэлтүүд системтэй бус, харин дур мэдэн тогтоогдож байгааг харуулж Таамаглал 1-ийг баталж байна.

3. Батлагдсан төсөвт өртөг нь “түргэн хөрвөх хөрөнгийн шалгуурын хэлбэр”-тэй системтэй хамааралгүй болох нь Kruskal–Wallis (p=.111) нотоллоо. Өөрөөр хэлбэл, Батлагдсан төсөвт өртөг өндөр тендэр санхүүгийн шалгуур үзүүлэлтийн босгын хувь өндөр байдаг гэсэн таамаглал 3 няцаагдлаа. Мөн таамаглал 5 Санхүүгийн шалгуур үзүүлэлтийн тоо батлагдсан төсөвт өртөгтэй хамааралгүй гэдэг нь батлагдлаа.
4. Банкнаас гаргуулах суурь нотлох баримтууд - Харилцах дансны үлдэгдэл (96%), харилцагч банкнаас авч болох зээлийн дүнгийн тодорхойлолт (97%), үнэт цаас (93%) практикт нэгдсэн хэрэглээтэй болсон боловч хуульчлагдаагүй, журамлагдаагүй тул тендер бүрд шаардлагын хэлбэр, агуулга өөр өөр байж оролцогчдод тэгш бус нөхцөл үүсгэсээр байна.
5. Энэхүү судалгааны үр дүнг үндэслэн санхүүгийн шалгуурын багцыг эрсдэлд суурилсан, стандарт болгон боловсруулах нь эрх зүйн хүрээнд хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

ПРАКТИК САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Санхүүгийн шалгуурын “стандарт багц” (борлуулалтын орлого, түргэн хөрвөх хөрөнгө, өр зээл, банк, аудитын нотолгоо)-г ажлын төрөл, эрсдэлийн ангиллаар нэг мөр болгох, тендер бүрт “өөр өөрөөр” тавигдахыг бууруулах
2. Судалгаанд үүсгэсэн кодчилсон мэдээлэлд тулгуурлан “санхүүгийн шалгуурын нэгдсэн сан” байгуулах (жил тутам update хийх) — дараагийн жилүүдийн тендерүүдэд стандартчлах суурь болох
3. “Төсөвт өртөг–шалгуурын хатуу байдал” холбоо сул гарсан тул төсөвт өртөгөөс шууд пропорциональ босго тогтоохоос илүү гэрээний эрсдэл, төрөл, цар хүрээнд суурилсан шалгуурын стандарт боловсруулах нь оновчтой

ХЯЗГААРЛАЛТ БА ЦААШДЫН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ

- Судалгаа нь зөвхөн нээлттэй мэдээлэлтэй 530 тендер дээр хийгдсэн бөгөөд төрийн нууцтай болон цуцлагдсан тендерүүдийг хамруулаагүй
- Энэ өгүүлэл нь зөвхөн Санхүүгийн шалгуурын модульд төвлөрсөн тул Техникийн шалгуурын модуль болон Боловсон хүчний модулийг авч үзээгүй болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Cao, F., & Wang, C. (2023). Corruption, accountability, and discretion of procurement officials: An analysis of selection Preferences for Performance-based Evaluation Criteria (PBEC) in PPP procurement. *PLOS ONE*, *18*(3), e0282542. https://doi.org/10.1371/journal.pone.0282542

Chartered Institute of Procurement and Supply, C. (n.d.). *How to prepare and evaluate tenders*. Retrieved https://www.cips.org/intelligence-hub/quality-measurement/tender-process/evaluation#item-block-1

European commisson. (2018). *Methodology for evaluating the financial capacity of tenders for public contracts*.

Gálvez-Rodríguez, M. D. M., López-Godoy, M., Saraite-Sariene, L., & Caba-Pérez, C. (2024). Worldwide Trends in Public Procurement Efficiency Studies Under the Lens of Award Criteria. *Sage Open*, *14*(4), 21582440241297400. https://doi.org/10.1177/21582440241297400

Liu, T., Wang, Y., & Wilkinson, S. (2016). Identifying critical factors affecting the effectiveness and efficiency of tendering processes in Public–Private Partnerships (PPPs): A comparative analysis of Australia and China. *International Journal of Project Management*, *34*(4), 701–716. https://doi.org/10.1016/j.ijproman.2016.01.004

Zedan Hatush, M. R. S. (1998). *Contractor selection using multicriteria utility theory: An additive model*. *https://www.sciencedirect.com/journal/building-and-environment/vol/33/issue/2*(2–3), 105–115. https://doi.org/https://doi.org/10.1016/S0360-1323(97)00016-4

Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хууль (2023). https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760359992351

Төсвийн Тухай Хууль (2011). https://legalinfo.mn/mn/detail?lawId=12254

Хөрөнгө Оруулалтын Тухай Хууль (2013). https://legalinfo.mn/mn/detail?lawId=9491

ХАВСРАЛТ 1

ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ — САНХҮҮГИЙН ШАЛГУУРЫН ХЭСЭГ

(ТШЗ 15.2, 16.1, 17.6, 18.1, 19.1 — Жишиг тендер ААИТСЗДТГ/20260201001)

Судалгааны чанарын кодчилол хийхэд ашиглагдсан өгөгдлийн хүснэгтийн санхүүгийн шалгуурын хэсгийг доор бүрэн дүүрэн эх хэлбэрээр хавсаргав. Энэ нь судалгааны 530 тендерийн нэгийг жишиг болгон харуулж байна.

ТШЗ 15.2 Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг шаардах эсэх:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгана. 2. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэл, татварын өр төлбөргүй тодорхойлолт болон шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу ирүүлнэ. 3. Татвар, Нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, мөн ШШГГ, гэрээний гүйцэтгэл ирүүлсэн захиалагч байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор ямар нэгэн шийтгэл авч байсан эсхүл гэрээний биелүүлээгүй нь нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. 4. ТБОНӨХБАҮХАТХуулийн 7.1.10-т заасны дагуу "Хүүхэд хамгаллын бодлого"-ыг тендерт хавсарган ирүүлнэ. 5. Оролцогч ТБОНӨХБАҮХАТХуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана.

ТШЗ 17.6 Санхүүгийн чадавхын шаардлага: "Шаардана"

Оролцогчид тавих санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлага: "Шаардлагатай" 1. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2024, 2025 оны дундаж батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх 2. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. 3. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.

ТШЗ 18.1 Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: "Шаардана"

2024, 2025 онуудын дундаж батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын гүйцэтгэгчээр ажилласан байх. Ижил төстэй ажлын гэрээний мэдээллийг V бүлгийн маягт-4 болон 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ. а. Ижил төстэй ажлын туршлагын шаардлагыг хангах ажил гүйцэтгэсэн гэрээг тендерт хавсарган ирүүлэх б. Ашиглалтанд хүлээн авсан комиссын дүгнэлтийг тендерт хавсарган ирүүлэх.

ТШЗ 19.1 Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: "Тийм"

Ажил гүйцэтгэх хүний нөөц: "Шаардана"

д/д	Албан тушаал	Мэргэжлээрээ ажилласан ажлын туршлага	Хүний тоо	Мэргэжил
1	Удирдах ажилтан	3 болон түүнээс дээш жил	1	Авто замын бакалавар
2	Инженер	3 болон түүнээс дээш жил	1	Авто замын бакалавар

ХАВСРАЛТ 2

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ КОД ТОГТООЛТ: САНХҮҮГИЙН ШАЛГУУРЫГ ХЭРХЭН КОДЧИЛСОН ТАЙЛБАР

(Жишиг тендер: ААИТСЗДТГ/20260201001 — Тайхар комплекс, Зогсоол замын ажил)

Энэхүү хавсралтад судалгааны чанарын кодчилолын аргачлалыг жишиг тендерийн өгөгдлийн хүснэгтийн 16-20 хуудасны санхүүгийн шалгуурын хэсэгт хэрэглэсэн байдлаар тодруулж харуулав.

1. Жишиг тендерийн өгөгдлийн хүснэгтийн санхүүгийн шалгуурын хэсэг

Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын А/104 дугаарт тушаалын дагуу батлагдсан жишиг баримт бичгийн II бүлгийн өгөгдлийн хүснэгт нь тендер шалгаруулалтын зааварчилгааны холбогдох заалтуудтай уялдсан бүтэцтэй. Санхүүгийн шалгуурыг агуулсан ТШЗ 17.6 болон ТШЗ 18.1-ийн хэсгийг доор харуулав.

Хүснэгт. Жишиг тендер (ААИТСЗДТГ/20260201001)-ийн санхүүгийн шалгуурын хэсэг — өгөгдлийн хүснэгтээс

ТШЗ-ны заалт	Агуулга (өгөгдлийн хүснэгтэд бичигдсэн байдлаар)
ТШЗ 17.6 (Санхүүгийн чадавхын шаардлага)	"Шаардана" 1. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2024, 2025 оны дундаж батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх 2. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх. 3. Банк, санхүүгийн байгууллагад...хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.
ТШЗ 18.1 (Туршлагын шаардлага)	"Шаардана" 2024, 2025 онуудын дундаж батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын гүйцэтгэгчээр ажилласан байх.

2. Кодчилолын аргачлал

Нийт 530 тендерийн санхүүгийн шалгуурыг кодчилоход дараах аргачлал баримтлаж кодлосон.

Хүснэгт. Хувьсагч тус бүрийн кодчилололд баримтласан арга зүй

№	Хувьсагч	Кодчилолын журам
1	sales_rev_coverage (орлогын хугацаа)	Тендерт дурдсан хугацааны тоог шууд тооцов: 1=1жил, 2=2жил, 3=3жил
2	min_src, min_crc (босго хувь)	Хувийн утгыг аравтын тоонд хөрвүүлэв: 30%=0.30, 80%=0.80
3	sales_rev_criteria (орлогын төрөл)	Орлогын тодорхойлолтын хэлбэрийг 6 категорид ангилав: 1=аль 1 жилийн орлого, 2=нийлбэр орлого 3=дундаж орлого, 4=төсөвт өртгийн хувь 5=татварын тодорхойлолт, 6=шаардаагүй
4	Lav, Tod, Legal (банкны баримт)	Шаардсан эсэхийг хоёртын кодоор тэмдэглэв: 0=шаардаагүй, 1=шаардсан
5	loan_criteria (өр зээл)	Зээлийн шалгуурын тодорхойлолтын төрлийг ангилав: 0=шаардаагүй, 1=хугацаа хэтэрсэн зээлгүй 2=зээлийн ангилал хэвийн 3=дуусаагүй зээлийн хэмжээ, 4=бусад
6	min_time (зээлийн хугацаа)	Зээлгүй байх шаардлагын хугацааг жилийн тоогоор кодолов